

АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

- Хэлтэс нь үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж музейн захирлаар батлуулна. Гүйцэтгэлийг сараар тооцож ажиллана.
 - Ажилтнууд 7 хоног, сарын төлөвлөгөөтэй ажиллана.
 - Хэлтсийн дарга нар нь ажилтнуудын төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр дүгнэж, захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.
- Хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх
 - Музейн захирал ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж жилд 1 удаа хэлэлцэнэ.
 - Хөдөлмөрийн гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангах, гэрээний хэрэгжилтийн явц байдлыг сар тутам хариуцах бөгөөд жил бүрийн 6,12 дугаар сарын 2 дахь 7 хоногт хүн нэг бүрийн тайланг авч дүгнэнэ.
 - Хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэхтэй холбогдсон зөрчил, дутагдлыг хамт олны болон хэлтсийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх буюу холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.